



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/187

Бат-Өлзий сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хогийг ангилан ялгах хоёрдогч түүхий эдийн цэг бий болгох ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)  
Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)  
А.Долгор-Өлзий (Бат-Өлзий тохижилт үйлчилгээ  
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал)

2.Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтыг боловсруулан 3-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжээс үнийн санал авч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсгийн ахлагч (Г.Бямбагарав)-д даалгасугай.

ДАРГА



С.АМГАЛАН